



ДОРНОГОВЬ АЙМАГ
УЛААНБАДРАХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/52

Нүдэн

Газар ашиглуулах дуудлага худалдаа
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын “Журам шинэчлэн баталж, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, “Улсын хэмжээнд 2026 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын хэмжээ, байршил, жагсаалт батлах тухай” 2026 оны 45 дугаар тогтоол, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Сумын Газар зохион байгуулалтын 2026 оны төлөвлөгөө батлах тухай” 2025 оны 21 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын газар зохион байгуулалтын 2026 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор тус сумын 3-р багийн нутаг дэвсгэрт Терминал (ачиж, буулгах талбай) зориулалтаар ашиглуулах газрын дуудлага худалдааг зохион байгуулсугай.

2.Дуудлага худалдаагаар ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалт, хугацаа, дуудлага худалдааны анхны үнэ, дэнчингийн хэмжээг хавсралтаар баталсугай.

3.Газар ашиглуулах дуудлага худалдааг 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдөр зохих журмын дагуу танхим хэлбэрээр зохион байгуулахыг Газрын даамал (Ц.Оюунцэцэг)-д үүрэг болгосугай.


4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (М.Мөнх-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБҮРЭН

2026 оны 04 дүгээр сарын 29 өдрийн
1132 дугаар захирамжийн хавсралт



АШИГЛУУЛАХ ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ, ЗОРИУЛАЛТ
ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ АНХНЫ ҮНЭ, ДЭНЧИНГИЙН ХЭМЖЭЭ

| № | Газрын байршил | Газрын зориулалт | Талбайн хэмжээ /м2/ | Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар | Дуудлага худалдааны анхны үнэ | Дэнчингийн хэмжээ | Газар ашиглах хугацаа | Зохион байгуулагдах хугацаа |
|---|--|---|---------------------|-----------------------------------|-------------------------------|-------------------|-----------------------|-----------------------------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1 | 3-р баг, Хулангийн шанд зөрлөгийн орчим | 2127: Терминал (ачиж, буулгах талбай) | 990207 | 5001513 | 594124200 | 59412420 | 5 жил | 2026.06.02 |